



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/50

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4, 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 19 сумын 22 цэгт малын гоц халдварт шүлхий өвчин бүртгэгдэн бусад сум багийн нутаг дэвсгэрт сэжигтэй тохиолдлууд илэрч байгаатай холбогдуулан аймгийн төв Мөрөн сумруу орох замуудын хяналтын цэгт ажилласан алба хаагчдийн хоолны материал авах, хоол хүргэх шатахууны зардалд 4.567.300 (Дөрвөн сая таван зуун жаран долоон мянга гурван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 4.567.300 (Дөрвөн сая таван зуун жаран долоон мянга гурван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Шуурхай штабын дарга (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН